

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/182/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх
захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/78

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 74,619.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019000102

Бусад асуудлын хэсэг

Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэг “Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90,7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>193,685,364.26</u>	<u>172,198,292.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	92,224,517.54	74,619,903.78
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	92,224,517.54	74,619,903.78
3121	Төгрөг	92,224,517.54	74,619,903.78
31211	Төрийн сангийн харилцах	92,224,517.54	74,619,903.78
33	АВЛАГА	449,113.21	649,113.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	351,973.52	551,973.52
335	Бусад авлага	97,139.69	97,139.69
3351	Байгууллагаас авах авлага	97,139.69	97,139.69
35	БАРАА МАТЕРИАЛ	101,011,733.51	96,929,275.51
351	Түүхий эд материал	50,000.00	50,000.00
35130	Эм боох материал	50,000.00	50,000.00
354	Хангамжийн материал	100,961,733.51	96,879,275.51
35410	Бичиг хэргийн материал	1,247,500.00	95,000.00
35420	Аж ахуйн материал	680,500.00	944,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,820,500.00	4,500,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,722,000.00	-
35450	Барилгын засварын материал	5,115,860.00	5,165,860.00
35460	Хүнсний материал	10,167,255.00	1,956,820.00
35470	Бусад хангамжийн материал	78,208,118.51	84,216,495.51
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>571,573,308.99</u>	<u>388,048,898.85</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	571,573,308.99	388,048,898.85
392	Биет хөрөнгө	550,921,908.99	374,965,898.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	541,472,106.87	369,233,766.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,273,079.74)	(27,904,697.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,553,752.63	44,034,928.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,957,088.46)	(26,882,949.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,429,262.96	37,217,267.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,545,774.37)	(33,171,407.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,890,000.00	22,531,616.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,980,000.00)	(14,425,355.20)
39217	Ном	4,332,729.10	4,332,729.10
393	Биет бус хөрөнгө	20,651,400.00	13,083,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,421,400.00	13,853,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>765,258,673.25</u>	<u>560,247,191.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,476.05</u>	<u>52,260.41</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,476.05	52,260.41

413	Өглөг	1,476.05	52,260.41
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,476.05	52,260.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	765,257,197.20	560,194,930.94
51	Засгийн газрын хувь оролцоо	765,257,197.20	560,194,930.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	789,854,011.21	789,854,011.21
51101	Өмч: - төрийн	789,854,011.21	789,854,011.21
512	Хуримтлагдсан үр дүн	(89,044,031.89)	(294,106,298.15)
51210	Өмнөх үеийн үр дүн	(89,044,031.89)	(89,044,031.89)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(205,062,266.26)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,447,217.88	64,447,217.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	765,258,673.25	560,247,191.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,553,768,181.79	578,617,748.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	672,642,081.79	6,119,051.13
120	Нийтлэг татварын бус орлого	672,642,081.79	6,119,051.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	588,815,526.68	1,762,174.13
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	430,558.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	130,037,800.00	55,531,697.07
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	751,088,300.00	516,967,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,696,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,696,300.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	108,341,500.00	55,531,697.07
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	108,341,500.00	55,531,697.07
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	788,862,958.11	783,680,014.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	788,862,958.11	783,680,014.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	760,640,105.93	778,877,053.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,174,836.27	389,007,820.65
210101	Үндсэн цалин	391,541,286.36	277,902,778.64
210102	Нэмэгдэл	87,723,405.52	100,206,017.76
210104	Урамшуулал	28,012,454.71	10,899,024.25
210105	Гэрээт ажлын хөлс	8,897,689.68	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,192,485.61	48,750,541.03
210201	Тэтгэврийн даатгал	46,538,923.29	33,220,913.37
210202	Тэтгэмжийн даатгал	4,922,549.85	3,885,159.37

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,937,979.77	3,108,127.44
210204	Ажилгүйдлийн даатгал	975,570.62	766,022.27
210205	Эрүүл мэндийн даатгал	9,817,462.08	7,770,318.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,812,223.76	55,496,678.48
210301	Гэрэл, цахилгаан	8,903,065.72	9,202,473.04
210302	Түлш, халаалт	49,624,158.04	46,144,205.44
210303	Цэвэр, бохир ус	285,000.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,266,950.00	5,009,500.00
210401	Бичиг хэрэг	5,632,200.00	3,292,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,634,750.00	1,717,100.00
2105	Нормативт зардал	79,976,920.00	77,076,077.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	922,700.00	-
210502	Хоол, хүнс	79,054,220.00	76,142,077.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	934,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	915,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	915,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,796,690.29	202,621,436.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,150,272.60	12,588,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,404,200.00	1,514,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,242,217.69	188,518,526.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,222,852.18	4,802,960.71
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,732,572.06	901,526.71
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,732,572.06	901,526.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,490,280.12	3,901,434.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,489,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,980.12	3,901,434.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>764,905,223.68</u>	<u>(205,062,266.26)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>764,905,223.68</u>	<u>(205,062,266.26)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>881,126,100.00</u>	<u>572,498,697.07</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,126,100.00	572,498,697.07
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	751,088,300.00	516,967,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,696,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,696,300.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	108,341,500.00	55,531,697.07
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	108,341,500.00	55,531,697.07
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>788,901,582.46</u>	<u>586,440,810.83</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	788,901,582.46	586,440,810.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	760,678,730.28	581,637,850.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,638,380.60	389,157,036.29
210101	Үндсэн цалин	395,004,830.69	273,917,540.05
210102	Нэмэгдэл	87,723,405.52	104,340,471.99
210104	Урамшуулал	28,012,454.71	10,899,024.25
210105	Гэрээт ажлын хөлс	8,897,689.68	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,824,604.92	48,750,541.03
210201	Тэтгэврийн даатгал	43,171,042.60	33,223,137.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,922,549.85	3,885,950.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,937,979.77	3,104,860.31
210204	Ажилгүйдлийн даатгал	975,570.62	765,869.68
210205	Эрүүл мэндийн даатгал	9,817,462.08	7,770,723.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,235,069.76	53,949,170.35
210301	Гэрэл, цахилгаан	8,903,065.72	8,802,964.91
210302	Түлш, халаалт	51,047,004.04	44,996,205.44
210303	Цэвэр, бохир ус	285,000.00	150,000.00
2105	Нормативт зардал	84,038,945.00	67,981,642.45
210502	Хоол, хүнс	84,038,945.00	67,981,642.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	681,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	681,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	915,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	915,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,521,730.00	20,203,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,771,730.00	16,889,460.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,750,000.00	3,314,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,222,852.18	4,802,960.71

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	901,526.71
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,732,572.06	901,526.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,490,280.12	3,901,434.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,489,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,980.12	3,901,434.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	92,224,517.54	(13,942,113.76)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	3,662,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,662,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,662,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал *	-	3,662,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(3,662,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	92,224,517.54	(17,604,613.76)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	92,224,517.54
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,224,517.54	74,619,903.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(188,658,427.65)	665,642,801.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(188,658,427.65)	665,642,801.44
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,729,416.13)	(7,729,416.13)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(89,044,031.89)	765,257,197.20
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(89,044,031.89)	765,257,197.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(89,044,031.89)	765,257,197.20
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(205,062,266.26)	(205,062,266.26)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,854,011.21	64,447,217.88	(294,106,298.15)	560,194,930.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	664,613,100.00	633,985,394.47	30,627,705.53	95.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	664,613,100.00	633,985,394.47	30,627,705.53	95.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,711,500.00	630,083,960.47	30,627,539.53	95.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,093,300.00	389,157,036.29	53,936,263.71	87.8
210101	Үндсэн цалин	295,726,000.00	273,917,540.05	21,808,459.95	92.6
210102	Нэмэгдэл	135,846,800.00	104,340,471.99	31,506,328.01	76.8
210104	Урамшуулал	11,520,500.00	10,899,024.25	621,475.75	94.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,170,900.00	48,750,541.03	6,420,358.97	88.4
210201	Тэтгэврийн даатгал	37,836,400.00	33,223,137.48	4,613,262.52	87.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,333,400.00	3,885,950.43	447,449.57	89.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,467,000.00	3,104,860.31	362,139.69	89.6
210204	Ажилгүйдлийн даатгал	866,700.00	765,869.68	100,830.32	88.4
210205	Эрүүл мэндийн даатгал	8,667,400.00	7,770,723.13	896,676.87	89.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,676,600.00	107,898,340.70	(53,221,740.70)	197.3
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	17,605,929.82	(8,605,929.82)	195.6
210302	Түлш, халаалт	45,076,600.00	89,992,410.88	(44,915,810.88)	199.6
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	300,000.00	300,000.00	50.0
2105	Нормативт зардал	80,724,600.00	67,981,642.45	12,742,957.55	84.2
210502	Хоол, хүнс	80,724,600.00	67,981,642.45	12,742,957.55	84.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	1,362,000.00	(612,000.00)	181.6
210604	Урсгал засвар	750,000.00	1,362,000.00	(612,000.00)	181.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,500.00	915,000.00	285,500.00	76.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,500.00	915,000.00	285,500.00	76.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,095,600.00	14,019,400.00	11,076,200.00	55.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,494,100.00	10,705,400.00	10,788,700.00	49.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,601,500.00	3,314,000.00	287,500.00	92.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,901,600.00	3,901,434.00	166.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,901,600.00	3,901,434.00	166.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	664,613,100.00	628,030,394.14	36,582,705.86	94.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	609,186,500.00	516,967,000.00	92,219,500.00	84.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	609,186,500.00	516,967,000.00	92,219,500.00	84.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,426,600.00	55,531,697.07	(105,097.07)	100.2
132001	Орон нутгийн төсвөөс	55,426,600.00	111,063,394.14	(55,636,794.14)	200.4

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	92,224,517.54		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	74,619,903.77		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	350.00	350.00	-	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	350.00	350.00	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	350.00	350.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд эрхлэгч 1, аргазүйч 1, багш 14, нярав 1, тогооч 3, галч 4, нийт 24 орон тоотойгоор ажиллаж, нийт 150 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж эцэг эхтэй шууд болон шууд бусаар хамтран ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Боловсролын ерөнхий хууль шинэчилсэн найруулга
- ✓ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 205,011.5 мянган төгрөгөөр буюу 27 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	92,224.5	74,619.9	(17,604.6)
Авлага	449.1	649.1	200.0
Бараа материал	101,011.7	96,929.3	(4,082.5)
Үндсэн хөрөнгө	571,573.3	388,048.9	(183,524.4)
Нийт хөрөнгө	765,258.7	560,247.2	(205,011.5)
Өр төлбөр	1.5	52.3	50.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	789,854.0	789,854.0	-
Хуримтлагдсан үр дүн	(89,044.0)	(294,106.3)	(205,062.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,447.2	64,447.2	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	765,258.7	560,247.2	(205,011.5)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн данс 17,604.6 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн зардал өмнөх өссөн тул илүүл зарцуулсантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 74,619.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал 4,082.5 төгрөгөөр буурсан нь тайлант онд 75,432.2 мянган төгрөгийн худалдан авалт, 4,356.9 мянган төгрөгийн хандиваар бараа материал орлогодож, 79,142.0 мянган төгрөгийн бараа материал шаардахын дагуу зарлагдаж, бүтцийн өөрчлөлтөөр 4,729.5 мянган төгрөгийн бараа материал шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 183,524.4 мянган төгрөгөөр буурсан нь 5,726.7 мянган төгрөгийн хөрөнгө тооллогоор акталж, бүтцийн өөрчлөлтөөр 224,153.4 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж өгсөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 609,186.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 55,426.6 мянган төгрөг, зарлагыг 664,613.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг нэмээгүй, бууруулаагүй баталсан байгаа нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй явуулсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 516,967.0 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 111,063.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 633,985.4 мянган төгрөг буюу 95.4 хувьтай зарцуулсан байгаа нь цалин хөлсний зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,800.70	1,800.00	0.70	99,9
2	81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	67,315.90	67,315.90	-	100,0
3	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	5,194.50	5,194.50	-	100,0
4	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,800.70	1,800.70	-	100,0
5	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	8,176.40	8,176.40	-	100,0
6	81834 Боловсролын стандарт, сургалтын	328,684.40	328,684.40	-	100,0
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	103,994.40	103,994.40	-	100,0
8	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	55,426.60	55,531.70	(105.10)	100,1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг хичээл үйлдвэрлэл 3,601.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 10,597.3 мянган төгрөгөөр, хоол хүнс 80,724.6 мянган төгрөгөөр нийт 94,923.4 мянган төгрөгөөр батлуулж гүйцэтгэлээр хичээл үйлдвэрлэл 3,314.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 9,647.9 мянган төгрөг, хоол хүнс 67,981.6 мянган төгрөг нийт 80,953.5 мянган төгрөг зарцуулсан 85.3 хувийн гүйцэтгэлтэй худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден Пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч Б.Ариунтуяа, Ц.Цацрал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден Пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 765,822.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,487.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,615.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт 159 мэдээ мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 9 мэдээлэл, 9 мэдээлэл байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 99,072.3 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлдэг байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 9,857.3 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тгaлгyиnау оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим баримтын бүрдэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой нийт 4 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	290.6	2	290.6	100
Албан шаардлага	2	10,167.3	2	10,167.3	100
Зөвлөмж	5	4,366.2	2	1,780.0	40
Нийт дүн	9	14,824.1	7	12,237.9	80

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,824.1 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 290.6 төгрөгийн актыг бүрэн барагдуулж, 10,167.3 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 5 зөвлөмж өгснөөс 2 нь хэрэгжиж, 2,586.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллах талаар анхаарал хандуулах болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,019.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 1,019.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 1 зөвлөмж хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөг, авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 649.1 мянган төгрөгийн авлагатай, 52.3 мянган төгрөгийн өглөгтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, 2023 онд газрын төлбөр 304.1 мянган төгрөг татвар, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 14.0 мянган төгрөг төлөөгүй санхүүгийн тайланд тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах, аудитын батламж мэдэгдлийн оршин байх "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг, авлага үүсгэхгүй ажиллах, тооцоо, нийлж үлдэгдлийг баталгаажуулдаг байх, үнэн зөв тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 649.1 мянган төгрөгийн авлагатай, 52.3 мянган төгрөгийн өглөгтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, 2023 оны 318.1 мянган төгрөгийн татварын өглөг тайлагнаагүй байна.	1	1,019.5					1	1,019.5				
Дүн	1	1,019.5					1	1,019.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 9 мэдээлэл хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 99,072.3 мянган төгрөг мэдээлээгүй.	1	99,072.3					1	99,072.3
Дүн	1	99,072.3					1	99,072.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим баримтын бүрдэлд 9,857.3 мянган төгрөгийн илүү байна.	1	9,857.3					1	9,857.3
Дүн	1	9,857.3					1	9,857.3
Нийт дүн	2	108,929.6					2	108,929.6

